

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийг 1994 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Энэ хугацаанд уг хуульд 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэ хүрээнд Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулсны дагуу цаашид өнөөгийн хот, тосгоны эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулийг шинэчлэн батлах үндэслэл бүрдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 4.3.4-д “шинэчлэн боловсруулсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд салбарын бусад хууль тогтоомжийг нийцүүлэх” гэж, 4.3.4.1-т “Хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах;” гэж, “Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг зохицуулах” гэж заасан хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.”, 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлт гэсэн дөрөвдүгээр бүлгийн 4.3-т “Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Өнөөдрийн байдлаар манай улсад 1 саяас дээш хүн амтай хот 1 (Улаанбаатар), 70.0-110.0 мянган хүн амтай хот 2 (Дархан, Эрдэнэт), 20.0-70.0 мянган хүн амтай хот 16, 10.0-20.0 мянган хүн амтай хот 8, нийтдээ 10,0 мянгаас дээш хүн амтай төвлөрсөн хот, суурин газар 27 болж, хотжилтын түвшин 70.7 хувьд хүрээд байна. Хот, суурин газрын хүн амын механик өсөлт, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад холбогдох аж үйлдвэрийн үйл ажиллагаа нэмэгдсэнээр нутаг дэвсгэр, хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд томоохон өөрчлөлт орж, хотжилтын

түвшин эрчимтэй өсч, хотын асуудлыг тухайлан зохицуулах, иргэдэд хотын үйлчилгээг хүртээмжтэй болгох шаардлага гарч байна.

Нэг төвт хотоос олон төвт хот Улаанбаатар хотын 1990 оноос хойш хүн ам 3 дахин өсөж, суурьшлын бүс 6 дахин тэлсэн байна. Үүнээс шалтгаалан худалдаа үйлчилгээ, дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний хүртээмжгүй байдал 61%-д хүрэн, Улаанбаатар хотын өдрийн 3 сая зорчилт хөдөлгөөний 1.7 сая хөдөлгөөн хотын төвийг чиглэж байна.

Тиймээс хотын төвийн төвлөрсөн эрх мэдэл, зорчилт хөдөлгөөний бөөгнөрөлийг дэд төвүүдийг түшиглэн, засаг захиргааны шинэчлэл хийх замаар нэг төвт хотоос олон төвт хотод шилжүүлэх шаардлагатай.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагыг харгалзан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Нийтлэг үндэслэл, Хот, тосгоны удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг, Хотын Зөвлөл, Хот, тосгон, хотын хорооны дарга, Хот, тосгоны төсөв, санхүү, эдийн засгийн үндэс, Хот, тосгоны удирдлага бусад этгээдтэй харилцах харилцаа, Хот, тосгоны оршин суугч болон Бусад зүйл гэсэн 8 бүлэг, 54 зүйлтэй байх бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалт тусгасан:

Нийтлэг үндэслэл гэсэн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, хот, тосгон, түүнийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, хотын зэрэглэл тогтоох, хот, тосгоны удирдлагын зарчим зэрэг асуудлыг тусгав.

Хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байж болох ба нэгжийн удирдлагын шилжүүлсэн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх нийтийн эрх зүйн этгээд байхаар тусгасан нь шинэлэг зохицуулалт юм. Хотыг улсын эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, хэрэгжүүлэх чиг үүргийн онцлогийг нь харгалзан дараах байдлаар ангилж, эрх зүйн байдлыг ялгаатай зохицуулсан:

- нийслэл Улаанбаатар хот;
- улсын зэрэглэлтэй хот;
- орон нутгийн зэрэглэлтэй хот.

Нийслэл Улаанбаатар хот болон улсын зэрэглэлтэй хот дагуул хоттой байж болно.

Тодруулбал, хот байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Засгийн газрын өргөн барьснаар Улсын Их Хурлаас шийдвэрлэх ба 100000 доошгүй оршин суугчтай, оршин суугчтай байхаар төлөвлөсөн хот нь улсын зэрэглэлтэй,

30000 доошгүй оршин суугчтай, эсхүл оршин суугчтай байхаар төлөвлөсөн хот нь орон нутгийн зэрэглэлтэй байх ба тосгон нь 2000 доошгүй оршин суугчтай байна.

Мөн хот, тосгон нь эдэлбэр газартай байх ба хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, өөрчлөх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэх ба эдэлбэр газартай үйлчлэх дүрэмтэй байхаар зохицуулсан. Хот, тосгоны дүрмээр ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн зориулалттай эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт зэрэг оршин суугчдын амьдрах эрүүл, аюулгүй, ая тухтай нөхцлийг бүрдүүлэх чиглэлээрх харилцааг зохицуулахаар тусгасан.

Хот, тосгоны удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг гэсэн Хоёрдугаар бүлэгт хот нь зохион байгуулалтын хувьд хотын хороонд хуваагдах ба тосгон нь хэсгийн зохион байгуулалттай байхаар зохицуулж, хот, тосгоны чиг үүргийг тогтоосон.

Хотын хороо нь оноосон нэртэй байх ба улсын зэрэглэлтэй хотын хороог 10000-аас доошгүй, орон нутгийн зэрэглэлтэй хотын хороог 8000-аас доошгүй оршин суугчтайгаар байгуулж, эдэлбэр газрын заагийг хотын Зөвлөл тогтооно.

Хотын удирдлагын тогтолцоо нь хотын Зөвлөл, хотын Захирагчаас бүрдэнэ.

Хуулийн төсөлд хот нь өөрийн удирдлага, зохион байгуулалт, эдэлбэр газар, хот бүрдүүлэгч дэд бүтэц, эдийн засгийн чадавх бүхийн нийтийн эрх зүйн этгээд болохын хувьд хэрэгжүүлэх нийтлэг чиг үүргийг тогтоосон. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу нэгжийн чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх үндсэн дээр хот, тосгоны оршин суугчдад төрийн үйлчилгээг хүргэх эрх зүйн орчныг хуулийн төсөлд бүрдүүлсэн.

Хотын Зөвлөл гэсэн Гуравдугаар бүлэгт хотын Зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагааны зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулсан. Тодруулбал, хотын өөрийн удирдлагын байгууллага нь Хотын Зөвлөл байх ба улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл оршин суугчийн тоо нь 200000 хүртэл бол 21, 200001-ээс дээш бол 25 гишүүнтэй байх бөгөөд Зөвлөлийг оршин суугчдаас сонгоно. Харин орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн хувьд оршин суугчийн тооноос хамаарч 11, 15 гишүүнтэй байхаар зааж, оршин суугчдаас сонгоно гэж зохицуулсан.

Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн ээлжит хуралдааныг сард нэг удаа зохион байгуулна. Хуралдааны дэгийг Зөвлөл тогтоолоор батлахаар хуулийн төсөлд тусгалаа.

Мөн хотын Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх, үйл ажиллагаанд нь хориглох зүйлс, бүрэн эрх дуусгавар болох, үйл ажиллагааны баталгаа зэргийг нарийвчлан зохицуулсан.

Хот, тосгоны Захирагч, хотын хорооны Захирагч буюу Дөрөвдүгээр бүлэгт, хот, тосгоныг өдөр тутамд удирдах, гүйцэтгэх удирдлагыг хот, тосгоны Захирагч, хотын хороонд хорооны Захирагч хэрэгжүүлэхээр тусгаж тэдгээрийн бүрэн эрх, Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох, огцруулах зохицуулалтыг тодорхой заасан. Хотын Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг тухайн хотын оршин суугчдаас сонгож Ерөнхий сайд батламжлах бол хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг тухайн хотын оршин суугчдаас сонгож, аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл улсын зэрэглэлтэй хотын Захирагч батламжилна гэж тусгасан.

Хот, тосгоны захирагч энэ хууль, бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байх ба ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газраас тогтоосон жишигт нийцүүлэн Захирагч тогтоохоор зохицуулсан.

Хот, тосгоны төсөв, санхүү, эдийн засгийн үндэс гэсэн Тавдугаар бүлэгт, хотын эдийн засгийн үндэс нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн орон нутгийн өмч, татварын болон татварын бус орлого, дэд бүтцийн сангийн болон бусад сангийн хөрөнгөөс бүрдэх ба хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах нь төр, орон нутгийн үүрэг байхаар зохицуулсан. Хот, тосгон нь төсөв, өөрийн өмчтэй байна.

Харин хот нь хотын татвар, хотын дэд бүтцийн болон Ногоон хөгжлийн зэрэг хотын хөгжлийн сантай байх бөгөөд хотод чөлөөт бүс байгуулж болохоор зохицууллаа.

Улсын зэрэглэлтэй хот болон нийслэлд харьяалагдахаас бусад орон нутгийн зэрэглэлтэй хот нь инженерийн болон дэд бүтцийг хөгжүүлэх, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт зэрэг үйл ажиллагаанд зарцуулах Дэд бүтцийн сантай байгуулах ба эх үүсвэрийг нь хуулийн төсөлд тодорхой тусгасан болно.

Хот, тосгоны удирдлага бусад этгээдтэй харилцах харилцаа гэсэн Зургадугаар бүлэгт, Засгийн газар, яам, агентлагтай улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагч нь шууд харилцахаар, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч нь тухайн хот харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцахаар тусгасан. Түүнээс гадна хот, тосгоны хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага оролцож болохгүй бөгөөд нэгжийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр нийтийн эрх зүйн гэрээ байгуулах зарчмаар нэгжийн удирдлагатай харилцахаар зохицуулсан.

Хот, тосгоны оршин суугч гэсэн Долдугаар бүлэгт, хот, тосгоны оршин суугчийн эрх, үүрэг, хот, тосгоны удирдлагад оролцох оролцоог зохицуулсан. Тодруулбал, хот, тосгоны амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар оршин суугчдын тодорхой хувь нь дэмжиж, гарын үсэг зурж хүсэлт гаргасан тохиолдолд хотын Зөвлөл хэлэлцэх, шаардлагатай тохиолдолд хот, тосгоны удирдлага санал асуулга зохион байгуулах үүрэгтэй байхаар тусгасан.

Бусад зүйл гэсэн Наймдугаар бүлэгт, хот, тосгоны бэлгэ тэмдэг, нэрэмжит цол, бусад шагналын талаар болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг заасан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу боловсруулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.3.1-д заасны дагуу

хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандах судалгааг хийх шаардлагагүй болно.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог холбогдох хууль, аргачлалын дагуу хийж, гарсан зөвлөмжийн тусган ажилласан.

Хууль батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн:

-улсын зэрэглэлтэй болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харилцаанд оролцох эрх зүйн үндэс бүрдэж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт хэрэгжиж, хууль хоорондын уялдаа хангагдаж, хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ;

-Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар суурин газруудыг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон болгон байгуулах асуудлыг дэс дараалалтай хэрэгжүүлэх боломж бүрдэнэ;

-улсын зэрэглэлтэй 5 /Дархан, Эрдэнэт, Шинэ Хархорум, Багануур, Налайх/ хотыг, орон нутгийн зэрэглэлтэй 44 хотыг /нийслэлд 14, аймгуудад 30: аймгийн төв-19 хот, Замын-Үүд, Тосонцэнгэл, Ханбогд, Цогцэций, Хөтөл, Мандал, Байтаг богд, Хатгал, Бор-Өндөр, Бэрх хот/, мөн дагуул 3 /Агросити, Багахангай, Шарын гол/ хотыг байгуулж, бие даан хөгжүүлнэ;

-хот, тосгон нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжээс тусдаа өөрийн удирдлагатай, санхүү, эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөл бүрдэнэ;

-хот, тосгод санхүү, эдийн засгийн бие дааснаар бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангана;

-бусад улсын хотуудын жишгээр хотын оршин суугчид хотын удирдлага сонгодог, хариуцлага тооцдог болно;

-хот, тосгод дүрэмтэй болж хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хот, тосгоны амьдрал, үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчдын оролцоотой шийдвэрлэдэг болно;

-хот, тосгон өөрийн оршин суугчдадаа төрийн үйлчилгээ буюу гагцхүү засаг захиргааны нэгжээр дамжих хэрэгжих үйлчилгээг хот, тосгоноор дамжуулан хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулна;

-Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн болон Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжиж, Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай зэрэг хуулийн төсөл, “Хот байгуулах тухай”, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулав.

2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хотын өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх хүрээнд хотыг өөрийн төсөв, татвартай байхаар зохицуулахтай холбогдуулан Нийслэл хотын албан татварын тухай хуулийг Хотын албан татварын тухай хууль болгон шинэчлэн найруулан боловсруулав.

---o0o---